

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР СУМ БАЯНХОНГОР НИСЭХ  
БУУДЛЫН ШАТАХУУНЫ АГУУЛАХЫН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**РЕГИСТЕРИЙН ДУГААР 2628546**

**Боловсруулсан: Шатахууны нярав, лаборант**

**М.Батчимэг**

**2023 он**

## ГАРЧИГ

### Төслийн товч танилцуулга

- 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл
- 1.2 Төслийн хүчин чадал
- 1.3 Аэродромын ашиглалтын нөхцөл
- 1.4 Төслийн дэд бүтцийн байдал

### Төсөлд хамрагдах Шатахуун түүний танилцуулга

- 2.1 Төслийн тодорхойлолт
- 2.2 Төслийн хүчин чадал

### Төслийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөөнүүд

- 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 3.2 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- 3.3 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөө
- 3.4 Орчны хяналт-шинжилгээний төлөвлөгөө

### Төслийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөөнүүд/шатахуун/

- 4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 4.2 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- 4.3 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- 4.4 Орчны хяналт шинжилгээний /хөтөлбөр/ төлөвлөгөө
- 4.5 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх ашиглах, нөхөн сэргээх, нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийн бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварийг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

БОМТ төсөл хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтлана.

БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уяалдсан байна.

БОМТ-ний хэрэгжилтийн төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчидын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүн хүрэх

БОМТ-ыг хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийн хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй байх зэрэг болно.

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Баянхонгор нисэх буудлын үйл ажиллагаа хүчин чадал

Тэртээ 1956 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 272-р тогтоолоор “АН-2” онгоц манай аймгийн Баян-Өндөр, Шинэжинст, Баянбулаг, зэрэг аймгаас алслагдсан сумдад анх нислэг үйлдэж эхэлсэн. Тухайн үед аймгийн төв нь галуут суманд байсан.

1976-онд одоогийн нисэх буудлын барилга ашиглалтад орсноор цагт 50 хүнд үйлчлэх хүчин чадалтай томоохон нисэх буудлын нэг болсон байна.

Одоо манай нисэх буудал нь цагт 120 хүнийг хүлээн авч үдэн гаргах хүчин чадалтай орчин үеийн техник, технологи, тоног төхөөрөмж бүхий, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан нисэх буудал юм.

- Тус нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, явгалах зам, перрон нь 1992 онд гэрэл суултын хамт дараах хэмжээтэй байгуулагдсан.
- ХБХЗ-2811м урт-35м өргөн,
- ЯЗ-600м урт-24м өргөн
- Перрон 120х56
- Гэрэл суултын нь нийт 152ш гэрлээр тоноглогдсон.
- Хамгаалалтын торон 180м өндөртэй 9650м урт.

Одоогоор агаарын зайн G ангилалтай

Аэродромын 3С ангилалтай үйл ажилгаа явуулж байна.

/Мөн өдөр шөнийн аль ч үед нислэг /хүлээн авах боломжтой/ одоогоор зөвхөн гэрэлтэй цагаар нислэг хүлээн авч байна. /

Одоо тус нисэх буудал нь 23 н ажилтантай үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ, Иргэний нисэхийн ерөнхий газрын сургалтын төвд мэргэжлийн анхан шатны болон давтан сургалтад жил бүр хамрагдаж үнэмлэх гэрчилгээжсэн мэргэжлийн ажилчид ажилладаг бөгөөд манай хамт олон иргэний нисэхийн дүрэм журамд нийцүүлэн нисэлгийн аюулгүй байдал ханган ажиллахын зэрэгцээ аймгийн ард эргэдэд хөнгөн шуурхай зөв боловсон үйлчилгээг эрхэм болгон ажиллаж байна.

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: Баянхонгор нисэх буудал, РД: 2628546

Төслийн нэр: “Баянхонгор нисэх буудлын шатахууны агуулах” тосол

Төслийн зорилго: Нисэх онгоцны шатахууныг зохих стандартын дагуу хадгалах. Газар эзэмших гэрчилгээний дугаар: 040700304, 103 га газар

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Баянхонгор аймаг Баянхонгор сум *Есөнбулаг* баг


Утас: 976-70442380

Майл хаяг: bayankhongor.airport@mcaa.gov.mn

Сайт: <https://www.mcaa.gov.mn/>

Төсөл хэрэгжих газрын орон,нутгийн харьяалал: Баянхонгор аймгийн Баянхонгор сумын *Есөнбулаг* багийн нутаг дэвсгэрт байрлана.

*ИНЕГ Төрийн өмчит Баянхонгор аймаг дахь салбар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна. Эрх бүхий этгээд нь Иргэний Нисэхийн Ерөнхий Газар байна.*



Зураг 1.2 “Баянхонгор” нисэх буудлын бүтэц, зохион байгуулалтын схем

Тус нисэх буудал нь баталсан орон тооны дагуу захиргаа аж ахуй, нислэг хөдөлгөөн аэронавигацийн хэсэг, аэродром ашиглалтын хэсэг, аюулгүй байдлын хэсэг, газрын тусгай үйлчилгээний хэсэг гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж нисэхийн аюулгүй байдал аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажлын зохион байгуулалтыг хийж ажиллаж байна.

Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт


### 1.3 төслийн байршил

“Баянхонгор” нисэх буудал нь Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 9-р багийн нутаг дэвсгэрт сумын төвийн урд зүгт 3 км, зайд оршино

! Зураг 1.4 “Баянхонгор” нисэх буудлын байршилын зураг



### 1.5 Шатахуун агуулах



“Баянхонгор” нисэх буудлын аэродромын байршилын газар зүйн үзүүлэлтүүд:

! » “Аэродромын лавлах цэг: 461003N”, 1004210E”

! » “Аэродромын өндөршил: дт 1867м

5 » “Температурын заалт : 25.6

## 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1. Газарзүйн байршил

Баянхонгор сум нь Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт сумдтай хил залган тал хээрийн бүсэд далайн түвшнээс 1845 метрийн өндөрт, 6.4 мянган хавтгай дөрвөлжин км талбай эзлэн оршино. Сумын төв нь Хангайн нурууны баруун өмнөд салбар Номгон уулын ар хормой, Түйн голын баруун эрэг дагуух элсэрхэг хөрстэй тал газар оршдог.

Төслийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай - Хэнтийн уулархаг их муж, Хангайн муж, Хангайн өмнөд бэгэлцэг хэсэгт багтах бөгөөд Засаг захиргааны хуваариар Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутагт оршино. Улаанбаатар хотоос газраар 650 км, агаараар 525 км алслагдсан байдаг.

### 2.2. Гоелогийн тогтоц

Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь-Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийг хамран говь хангайн бүсийг дамнан оршдог аймаг юм. Иймд нутаг нь уул тал хөндий хосолсон хэлбэр бүхий гадаргатай юм. Нутгийн хамгийн өндөр цэг нь Говь-Алтайн нурууны оргил 3957 м өргөгдсөн Их богд бөгөөд хамгийн нам цэг нь Алтайн өвөр говьд 750 м өндөр юм. Зээрэнгийн хөндий, Номингийн говь зэрэг Алтайн оврийн их говиуд бий. Говь-Алтайн ууланд 1957 онд газар хүчтэй хөдөлж, Ихбогд, Баянцагааны араар 300 орчим км үргэлжилсэн их хагархай гарсан юм. Баянхонгор аймгийн нутагт чулуун нүүрс, алт, барилгын материал элбэг байдаг. Байдраг, Түй зэрэг томоохон гол мөрдтэй, Бөөнцагаан, Орог нуур, Хөх нуур зэрэг том нууруудтай. Мөн 95 хэм хүрдэг халуунтай Шаргалжуутын рашаан болон Өүхэг рашаан, Хүрэмт рашаан, Халиут рашаан, Өргөөтийн рашаан гэж сайн рашаанууд бий. Баянхонгор аймгийн нутгийн хойд хэсэгт уулын хар шороон ба нутгийн хөрс, дунд хэсгээр нь тал хээрийн хүрэн хөрс, урд хэсгээр нь говийн саарал хөрс тархжээ.

### 2.3. Геоморфологи

Богдхан уул нь хотгор гүдгэрийн хувьд Сибирийн геоморфологийн мужийн Хэнтийн мужид багтана. Уул 2000 м, түүнээс дээш өргөгдсөн хавтгай бөмбөгөр оройтой, шинэхэн тектоник хөдөлгөөний өмнөх (палеоген-неогений) үед үүссэн эртний тэгшрэлийн гадарга зонхилох бөгөөд неогений сүүл үеийн уул үүсэх хөдөлгөөнөөр төдийлөн өөрчлөгдөөгүй үлджээ. Одоогийн хотгор гүдгэр нь тэгшрэлийн гадаргын үлдэц бүхий нэгэн цулдам уулсын тогтолцоог үүсгэх боловч олон тооны голын хөндий, амуудаар зүсэгдэж, хэрчигдсэн байхаас гадна уулын хажуу чулуун нураг, асга ихгэй, ихэнхдээ эгц огцом байдаг. соморфологийн зургаар уулын хотгор гүдгэрийг гарал үүслийн хувьд тектоник-идэгдэл-элэгдлийн, идэгдэл-элэгдлийн, элэгдэл- хуримтлалын гэсэн 4 үндсэн хэв шинж, 8 дэд хэв шинжид ялган зурагласан байна.

**ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ нөлөөллийн товч  
ТОДОРХОЙЛОЛТ**

Шатахууны агуулахын нефтийн бүтээгдэхүүнийг нөөцөлж, шатахуун түгээгүүрээр дамжуулан хэрэглэгчдэд жижиглэн борлуулалт хийх ажлын байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг магадлан жа, саах арга болон матрицын аргаар тодорхойлов. Болзошгүй нөлөөлөлд үнэлгээ өгөхдөө өмнө хийсэн суурь үнэлгээ болон Монгол оронд нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах, ашиглах үйл ажиллагаа эрхлэхэд гарч болох сөрөг нөлөөлөл, НҮБ-ын ази номхон далайн эдийн засгийн нийгмийн комиссоос гаргасан аргачлал зэргийг ашигласан болно.

Магадлан жагсаах арга нь нөлөөллийн “байна”, “байхгүй” гэсэн зарчим дээр тулгуурладаг бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ бид 2 төрлийн жагсаалт гарган ашигласан. Үүний нэг нь нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим шил зэргийг харуулдаг бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах нөлөөлөл, буцахгүй байх, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд ямар байхыг үзүүлдэг.

Нефтийн бүтээгдэхүүн нь орчин үеийн нийгмийн өдөр тутмын, зайлшгүй хэрэгцээний зүйл боловч, тээвэрлэлт, хадгалалт, үйлчилгээ, хэрэглээний шинжээс хамаарч, хүн, түүний хүрээлэгч орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөөтэй Энэ нөлөөг хүн дээр авч үзвэл энгийн цочроох үйлчлэлээс гүнзгий хордлогод оруулах, орчны доройтлыг бий болгохоос бүс нутгийн хэмжээнд экологийн сүйрэл бий болох аюултай байдгаар тодорхойлогддог. Сөрөг нөлөө үр дагаврыг нь авч үзвэл:

*Нефтийн бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл*

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Сөрөг нөлөө	Үр дагавар
1	Цаг уур, агаар мандал	-Агаарт нүүрстөрөгч, хүхрин нэгдлүүд, азотын нэгдлүүдийг дэгдээх -Хэт халсан агаарт шаталг үүсгэх -Агаарт бензиний уур, ялангуяа алхнууд алдагдах	-Агаар дахь O <sub>2</sub> -ийн хэмжээг багасгах, нүүрсхүчлийн болон хүхэрт устөрөгчийн, аммиакийн хэмжээг хэт ихэсгэх -Агаарт бензиний уур 0,03% болсон үеэс хүн мэдэрч эхлэх ба ийм агаараар хүн удаан амьсгалбал мэдрэлийн олон хэлбэрийн гэмтэл булчин сулрах, ядрах, эцэж турах, хоолонд муудах зэргээр



2	Гадаргын болон газар доорхи ус	-Гадаргын усанд бензин, дизелийн гүлшний хальс үүсгэнэ -Усанд ууссан O2-ийг өөртөө уусгаж исэлдэнэ -Усанд гидро урвалд орж давирхай үүсгэн ёроолд живэх -Газар доорхи усанд дээрхээс гадна маш удаан хадгалагдаж хүхрийн оксид (802,803) үүсгэн усыг идэмхий шинж чанартай болгодог - Усанд удаан задардаг 4этилд хар тугалгыг бнй	-Усанд O2-ийн дутагдал бий болгох.усны химийн найрлага ялангуяа идэмхий шинжийг нэмэгдүүлэх -Уснаас ууж хэрэглэсэн хүн, амьтан, шувуудад хордлого, торол бүрийн хавдар үүсэх болон урьдчилан тааварлах боломжгүй өвчлөлүүднийг бий болгож үхэл сүйрэлд хүргэнэ
3	Амьтны аймаг түүний экологи	-Нефтийн бүтээгдэхүүн усанд алдагдсанаас усны амьтдын амьдралын орчин доройтно -Ундаалах үүсвэрнийг хомсдуулна.	-Усанд амьдрах амьтны экологийг үндсээр нь өөрчилж O2-ийн дутагдал орж агаарын солилцооны үйл явцыг багас ч, улмаар үхэлд хүргэх -Ургамал, бусад бичил биет амьтан зоо хүнд металлаар хордох, идэш тэжээлийн хомсдол бий болгох, үхэл сүйрэлд хүргэх
4	Хөрс, ургамал. ойн бүрхэвч	Газрын хөрсөнд он удаан жил хадгалагдаж задралынхаа явцаар	-Ингэснээр хөрсний ялзмаг бодисын хэмжээг багасгаж, хар тугалгын хэмжээг нэмэгдүүлж,

*Дээрх хүснэгтээс харвал нефтийн бүтээгдэхүүн хүн, түүний хүрээлэгч орчинд үзүүлэх сөрөг нөлөө маш өргөн бөгөөд, энэхүү нөлөөллийн хязгаарыг тогтоох асуудал маш чухал юм.*

Агаарын чанар: Төслийн талбайд агаарын чанарын шинжилгээг тогтмол хийдэггүй бөгөөд судалгаа хийх явцад бохирдол илрээгүй болно.

Гадаргын усны нөөц, онцлог

Төслийн талбай ус зүйн сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Орог нуур - Түйн ай сав газарт (Монгол орны усны сав газрын 22-рт) багтана.

Түй гол нь Хангайн нурууны Хөх саяны давааны өврөөс эх авч Ориг нуурт цутгана. Голын ус хурах талбай 8404 км<sup>2</sup>, голын урт 243 км юм. Түйн голын онцлог бол Хангайн нурууны өврөөс эх авах голуудын адил урсацын алдагдал их байх ба жинст сумын орчимд гарар доогуур шургаж ахин ил гардаг онцлогтой. Түйн голын олон жилийн дундаж урсац Баянхонгор хотын орчимд 3.15 м<sup>3</sup>/с, Богд сумын орчимд 1.9 м<sup>3</sup>/с байдаг. Түйн голын усны тэжээгдэлийн 36% ул хөрсний ус, 16% хайлсан цасны ус, 46% хур борооны ус эзэлдэг байна.

Түйн гол нь 5 дугаар эрэмбийн гол юм. Голдрилын дундаж ондор 1764 м, ус хагалбарын шугамын дундаж урт 529.5 км, түүний дундаж ондор 3080 м, голуудын нийлбэр урт 4461.2 км, усан сүлжээний нягтшил 0.53 км/км<sup>2</sup>, хөндийн гүн дунджаар 1316 м, түүний өргөн 36,7 км, хортонь хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.0, 3.25, 6.31 тус

Тайлан боловсруулсан: "СОЛОНГОНТӨГӨЛ" ХХК

тус байна. Онги голын сав газрын голууд эхэн, дунд адаг хэсгээс ашиглаж болох усны хэмжээг эрдэмтэн Г.Даваа нарын тодорхойлсноор авч үзэхэд голуудын зөвхөн дунд хэсгээс 5-8 хувийг буюу 50-90 хувийн хангамшилтай үед 7.5 хувийг нь ашиглаж болох боломжтой.

*Их урсац.* Хээрийн судалгааны үед төсөлд хамрагдсан гол, сайруудын үндсэн чиглэлүүдийн солбицлыг 6P8 багажаар тогтоож, голын гольдрилын дагуу болон хөндлөн зүсэлтийг үерийн үлдээсэн ул мөр, гольдрилын хэлбэр, оршин суугчдаас авсан аман судалгаа зэрэг дээр үндэслэн түүхэн их уер хүрэх түвшин хүртэл гол горхины гольдрил, тутамд хөндлөн зүсэлт хийж, голын гольдрил, үерийн татмын хөрс чулуулгийн бүтэц, адраашлын итгэлцүүр, ургамалшилын байдал зэргийг газар дээр нь тодорхойлов.

Хаврын шар усны үер. Судалгаанд хамрагдаж байгаа бус нутгийн гол горхи болон түүний цутгал сайруудын шар усны үер хавар дунджаар 4 дугээр сарын дунд арван хоногоос эхэлж, 5 дугаар сарын дунд арван хоногт дуусах ба зарим жилүүдэд 3 дугаар сарын сүүлийн арван хоногт эхэлж, 5 дугаар сарын сүүлийн арван хоногт дуусах тохиолдол байдаг байна. Энэ бус нутгийн голуудын шар усны үер нь үерлэх хугацаа, үерийн хэмжээгээр ч зуны хур борооны үерээс харьцангуй бага юм. Гэхдээ зарим жилүүдэд голуудын шар усны үер нь ургэлжлэх хугацаа, үерийн хэмжээгээр хур борооны үерийг давах тохиолдол байдаг байна.

Хөрсний төлөв байдал:

Шинжилгээний дүнгээр зүсэлт-1 дээр хөрсний өнгөн үе давхаргадаа хөрсний ялзмаг агуулалт 1.21 буюу хангалтгүй, 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор 2.5 мг, кали 13 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 13 мг-эquiv байгаагаас үзэхэд шим тэжээлийн хангамж бага зэрэг байна. Гүнрүүгээ шим тэжээлийн үзүүлэлтүүд буурах хандлагатай. Хөрсний урвалын орчин өнгөн болон В үе давхаргадаа шүлтлэг шинж чанартай.

Нисэх онгоцны буудлын хяналтын цэгээс 3 км дотор хийсэн хөрсний Зүсэлт-2 ялзмаг агуулалт 1.46 буюу бага хангамжтай, 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор 1.1 мг, кали 16 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 16 мг-эquiv орчим байгаагаас үзэхэд шим тэжээлийн хангамжаар бага зэрэг байна. Хөрсний урвалын орчин рН 8.0 буюу шүлтлэг шинж чанартай. Дээж- 2 хувьд хөрсний ялзмаг агуулалт 1.154 буюу маш бага хангамжтай, 100 гр хөрсөнд агуулагдах хөдөлгөөнт фосфор 1.1 мг, кали 15 мг, шингээгдсэн сууриудын нийлбэр 20 мг-эquiv орчим байгаагаас үзэхэд шим тэжээлийн хангамжаар дунд зэрэг байна. Хөрсний урвалын орчин рН 8.1 буюу шүлтлэг шинж чанартай.

Ургамлан нөмрөг:

Баянхонгор аймгийн Баянхонгор суманд байрлах ИНЕГ-ын харъяа нисэх буудлын талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор хойноосоо Хангайн уулын тайгын тойрог, урдаасаа Олон нуурын цөлөрхөг хээрийн тойргийн хээрээс цөлрүү шилжих зурвас хэсэгт хамаарагддаг

Баянхонгор аймгийн “Баянхонгор” нисэх буудлын шатахууны агуулах нь аймгийн төвөөс баруун урд зүгт 2,2 км зайд орших бөгөөд тус нисэх буудал орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хангайн нуруунд хамаарна. Энэхүү мужид баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон Хангайн нурууны уулсын систем бүхэлээрээ хамаарах бөгөөд хамгийн баруун хойд салбар уулс болох Ханхөхийн нуруу, Булнайн нуруу, төв хэсэгтээ Хангайн нуруу, Тарвагатайн нуруу

Баянхонгор нисэх буудлын шатахууны агуулах төслийн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан Бүрэнгийн нуруу, Зэд-Хантай, Бүтээлийн нурууг хамран оршино. Амьтны аймгийн хувьд Баянхонгор аймгийн хойд хэсгийн багахан нутаг дэвсгэр энэ мужид хамаарна.

Хүснэгт 1

Хөрс, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийн эрчмийн үнэлгээ.

	Үзүүлэх нөлөө	нөлөөгүй	Үр дагаварын чанарын үнэлгээ			Аюултай
			бага	дунд	их	
1	Бүтээн байгуулалтаар хөрс хуулна			*		
2	Шимт хөрсийг түр хадгалах шаардлага үүснэ		*			
3	Нисэх буудлын үйл ажилгааны хатуу, шингэн		*			

Тайлбар: \* - үнэлгээг үзүүлсэн "СЭЛЭГ" БҮГДЭЛ " ХХК

- хог хаягдал гарч хөрс  
бохирдуулна
- 4 Халаалтын хэрэгцээний  
уурын зуух нь нүүрс х  
хэрэглэх, үнс гаргана.
- 5 Энгийн нүхэн жорлонг \*  
хустгаж үгүй болгосон

*Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө:*

Нисэх хамгаалалтын зурвас доторхи ургамалжилтай хэсэг нь байгалийн ургамалан нөмрөгөөс илүү ургацлаг байх тул тэнд мэрэгчид олшрон байрших нөхцөл болно. Тиймээс нисэх буудлын аюулгүйн зурвас дахь олон наст өвсөн бүрхэцийг тодорхой хугацаагаар хадаж намсгаж, биомассыг нь бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна. Бүс нутгийн ургамалжилтийн байдал, ургамалжилтанд нөлөөлөх байгалийн хүчин зүйл, нисэх буудлын үйл ажиллагаа зэргийн уялдаа холбоо, ургамалан нөмрөгт төслөөс үзүүлэх нөлөө зэргийг авч үзээд нөлөөллийг эрчмийн аргаар үнэлвэл сөрөг нөлөөллийн эрчим маш багаас бага зэргийн түвшинд үйлчилж байна.

*Хүснэгт 2.*

*Ургамал, Ургамалан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эрчмийн үнэлгээ.*

	Үзүүлэх нөлөө	Үр дагаварын чанарын үнэлгээ				
		маш бага	бага	дунд	их	онц аюултай
1	Нисэх буудлын өргөтгөлийн ажиллагаагаар хуулагдахад хэсэгчилсэн ургамалан устана.		*			
2	Нисэх буудлын ажиллагаагаар хамгаалалтын зурвас дахь ургамалжилт нь бэлчээрийн ачаалал авахгүй болсон байна.					
3	Нисэх буудлын хамгаалалтын зурвас доторхи ургамалжилтанд үндэсний үржил идэвхитэй болсоноор мэрэгчидийг ихээр цуглуулна.		*			
4	Нисэх буудлын ашиглаж байгаа хогийн цэг бага зэргийн бохирдол үүснэ.					
5	Нисэх буудлын ажиллагаанаас шалтгаалж бүс нутгийн ургамалжилтийн байдал өөрчлөгдөхгүй.		*			

	Нисэх буудлын үйл *	
6	ажиллагаанаас шалтгаалж бүс нутгийн ургамалжилтийн байдал өөрчлөгдөхгүй.	
7	Нисэх буудлын ногоон байгууламжыг шинээр нэмж байгуулна	*
	Нөлөөлөл	Ургамал, ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг нийт 7 үзүүлэлтээр үнэлхэд 42,9 хувь нь маш бага, 57.1 хувь нь бага зэргийн түвшинд байна. Ургамал, ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөө одоогийн байдлаар дунд зэргийн төвшинд хүрэхгүй эрчимтэй байна.

Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөө;

Нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотойгоор нисэх буудал орчимд тохиолдох амьтны аймагт дараах байдлаар бам болон шууд нөлөөг үзүүлнэ. Үүнд; Аэродромын орчинд агаарын хөлгийн өндөр алдах, газардах болон хөөрөх, өндөр авах үед хөхтөн амьтан болон шувууд онгоцтой мөргөлдөх, эндэх, агаарын хөлөгт аюул учруулах. Нисэх буудлын гаднах болон доторх дэд бүтэц буюу өндөр хүчдэлийн шугамд том биетэй нүүдлийн шувууд болон махчин шувууд хүчдэлд цохиулж үхэх эрсдэлтэ

1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 2023 онд

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>Агаар орчин</b>						
Онгоц хөөрөх болон буух үед агаарт тоосжилт ихээр үүсэх, агаарын хөлгөөс хорт хий ялгарах,	Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХ- ээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур, гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	--*--	--*--	Төлөвлөгөөний бүх үе шатанд	Агаарын тухай хууль, - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага  Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3- 16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд)
	Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	40.0	40.0 x 4 сар =160,000	Улиралд 1 удаа	
<b>Дуу чимээ</b>						
Онгоц хөөрөх, буух үеийн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ	Ажилчдыг дуу шуугианаас Хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Нисэх буудлын ажилчид	--*--	Үйл ажиллагааны зардалаар	Жилийн эхэнд	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ MNS 5002:2000  Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.

Усны нөөц, чанар						
Унд ахуйн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	Унд ахуйн хэрэглээний усанд тогтмол хяналт тавьж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	--*--	--*--	Улирал тутам	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх	Үйл ажиллагаанаас гарч буй бохир усанд шинжилгээ хийлгэж, тэмдэглэл хөтөлж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	30.0	30.0 x 4 удаа =120.000	Улиралд нэг удаа	Усны тухай хууль - MNS 6148:2010.
Хатуу хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох, цэвэрлэх байгууламжийн ажиллагааны горимыг алдагдуулах;	Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	--*--	Тоолуурын заалтын дагуу	Тухай бүр	Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ,
Хөрс, ургамлан бүрхэвч						
Бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс орчны хөрс бохирдох нөхцөлтэй; Ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх; Ахуйн гаралтай хатуу,	Хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсний бохирдлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	20.0	20 x 4 удаа 80,0	Улиралд нэг удаа	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,
	Ахуйн хатуу хог хаягдлыг хадгалах зориулалтын битүүмжилсэн хогийн савтай болох	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	300.0	300.0	2023 онд	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч

шингэн хаягдлаар хөрс бохирдох.	Гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	250,0	250,0	2023 онд	бодис,
---------------------------------	---	-----------------------------------	-------	-------	----------	--------

	Ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	--*--	--*--	Сар бүр	элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
--	---	-----------------------------------	-------	-------	---------	--

**Амьтны аймаг**

	Амьтан, мал нисэх зурвас, нислэгийн талбай руу орж дайруулж, гэмтэхээс сэргийлж тус нисэх буудлын хамгаалалтын хашааг жил бүр тордон засаж, сэлбэж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	200,0	200,0 x 4 жил = 800,0	Улирал бүр	
	Суваг шуудуу, далан байгуулахдаа амьтад унаж бэртэх, орж үхэх зэргээс сэргийлж хамгаалалт хийж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	--*--	--*--	Жилдээ	
	Мөн тус төслийн үйл ажиллагааг өргөжүүлж барилга байгууламж барих, зам талбай тавих, өргөтгөх явцад бий болсон цооног, нүх зэргийг дор бүр нь дүүргэн тэгшилж, өнгөн хөрсийг нөхөн сэргээлтэд ашиглаж байх	Барилгын ажлын үед	--*--	--*--	2022 онд	



	<p>Нисэх буудлын ойр орчмын амьтны амьдрах орчныг бусниулах, үргээх, агнаж устгах аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, оготно, хулгана хэт олширсон тохиолдолд тэдгээрийн тоо толгойг зохицуулах (зөвхөн хавх тавих, химийн бодис ашиглахгүй байх), хамгаалах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх</p>	<p>Нисэх буудлыг төлөвлөгөөний дагуу</p>	<p>200,0</p>	<p>200,0x1 = 200,0</p>	<p>Жилдээ</p>	
<p>Жилийн дүн</p>	<p>1.700.000</p>					

2. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 2023 онд

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	-	-	Өдөр бүр, тогтмол ажил эхлэхээс өмнө	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1, MNS4995:2000. ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” - MNS ILO OSH1:2003. ХААЭА-н удирдлын тогтолцооны талаарх удирдамж  MNS ILO OSH0:2003. ХААЭА. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS5002:2000. ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS5390:2004. ХААЭА. Цахилгааны галы аюулгүй байдал. Ерөнхий шаардлага - MNS ISO13688:2000. ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага  Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль MNS 4996 : 2000. “Ажлын байрны гэрэлтүүлгийн норм”
	Ажилчдыг эрүүл мэндийн эрүүл үзлэгт хамруулах	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	50.0	26 хүн x 50.0 =1.300.00	Жилдээ	
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт	бүх ажилчдад	200.0	200.0 x жилд 4 удаа = 800.000	Сургалтыг улиралд 1 удаа удаа	
	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт	бүх ажилчдад				
	Ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт	Бүх ажилчдад				
Байгаль орчныг хамгаалах талаарх сургалтуудыг зохион байгуулах	бүх ажилчдад					

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг  /мян.төгрөг/	Нийт зардал  /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Төслийн хүрээнд	Галын хор 20 ш x 50.0 = 500.0  Бусад -200.0	Нийт= 700.0	Жилдээ  1 удаа	
	Жилийн дүн			2,800,000		

3.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 2023 онд

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу болон ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу болон ахуйн хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулж байх  /сард 3-4 удаа/	Жилд 12 удаа x25.0 =900.000	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг зайлуулж буй цэвэршүүлэх байгууламжтай холбогдож буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Төлөвлөгөөний дагуу	Үйл ажиллагааны зардалд тусгах	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах		Үйл ажиллагааны зардалд тусгах	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Жилийн дүн		900.000	

4.Орчны хяналт-шинжилгээний /хөтөлбөр/ төлөвлөгөө 2023 онд

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар: Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх.  БОШТЛ-ын багажаар.	Нисэх буудлын талбайд цэг сонгох	Агаарын найрлага: Улиралд 1 удаа буюу жилд 42 удаа	Багажийн түрээсийн зардал: 1 багаж  300.0 x 4 сар  = 1,200.0 төг	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,</li> <li>- MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,</li> <li>- MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга</li> <li>- MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,</li> <li>- Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд)</li> </ul>
2	Усны хяналт шинжилгээ:	Бохир усанд	Улиралд 1 удаа.	30.0 x 4сар = 120.0	<ul style="list-style-type: none"> <li>- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж</li> <li>- MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага</li> <li>- MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж</li> <li>- MNS 13.060.50 Усны чанарын стандарт</li> <li>- MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт</li> </ul>
3	Хөрсний төлөв байдал, бохирдол:	гадна талбайд цэг сонгох	Улиралд 1 удаа.	Нийт 1 цэгт x 2 дээж x удаа =160.0	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,</li> <li>- MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,</li> <li>- MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг</li> </ul>

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
4				/Хөрсний химийн шинжилгээ 1дээж- 20.0₮, хүнд металлын шинжилгээ 1дээж - 20.0₮/	<p>тодорхойлох лабораторийн арга,</p> <ul style="list-style-type: none"> <li>- MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга</li> <li>- MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага</li> <li>- MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга</li> <li>- MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга</li> </ul>
5	Амьтан, шувуудыг бүртгэн тэмдэглэж, популяцийн төлөв байдал, нүүдэл, шилжилт хөдөлгөөн, зүйлийн бүрдлийг хянах	Нисэх буудлын ойр орчимд	Нүүдлийн хугацаанд жилд 2 удаа (10-11 дүгээр сар, 4-5 дугаар сарууд)	100,0 x 2 удаа = 200,0	Амьтдын судалгааны хээрийн бичиглэл хийх зааварчилгаа, Биологийн хүрээлэн, 1992, Хээрийн бичиглэлийн асуулга ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс боловсруулсан Зэрлэг амьтдын популяцийн анхан шатны мэдээлэл цуглуулах арга зүй
Жилийн дүн				1,700,000,00	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2023 онд нийт 7.300.000 төгрөгийг төлөвлөсөн.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 2023 он /Шатахууны агуулах/

№	Чиглэл	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Газрын гадарга, хэвлий		Ажилтан албан хаагчдыг тоосны нөлөөллөөс хамгаалах, машин техникийн дотоод орчны битүүмжлэлийг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдлаар хангах	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан.			Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ / БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4 –“ Зүлэг, талбайн усалгааны түр норм/ MNS 4943:2014 Усны чанар, хаягдал бохир ус, Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБУ тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
		Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, шатах тослох материалын ууршилт, ажилчдын суурингаас бохирдуулагч бодис агаарт тархах	Шатах тослох материал хадгалах сав, машин механизмуудын хорт хий ялгаруулалтанд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол хийж, хорт хийн ялгаралтыг стандарт түвшинд барьж байх	БОХШХ болон засвар үйлчилгээний ажилд хамаарна.			
		Шатах тослох материал, ажилчдын ахуйн бохир, хог хаягдлаас үүсэх таагүй үнэр	Хатуу хог хаягдлыг тогтмол тээвэрлэж, хогийн нэгдсэн цэгт хаях, хогийн савыг цэвэрлэж, ариутгаж байх	Бүх хогийн савыг хамруулна	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан.		

2	Газрын гадарга, хэвлий	Дэд бүтцийн барилга байгууламжууд, суваг шуудуу, ашиглагдаж буй зам талбай, машин техникийн зогсоол, авто засвар зэргээс газрын гадаргад өөрчлөлт гарах	Онц шаардлагатайгаас бусад талбайд үйл ажиллагаа явуулахгүй байх, ашиглахаар төлөвлөлөснөөс бусад орчны газрыг эвдрэлд өртөгдөхөөс аль болох зайлсхийж, автомашин явах зам, зогсох талбайг нарийн тогтоох	Агаарын бохирдлоос сэргийлэх арга хэмжээнд тусгагдсан	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ Энэ стандартаар Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд тус стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдолд орсон гэж үзнэ.
3	Хөрс	Машин механизмын явалт, тоног төхөөрөмжийн суурь, автомашины нөлөөгөөр хөрс нягтарч, доош суух, доройтох, элэгдэж эвдрэх, зулгарах, физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах	Ашиглагдаж буй түр зам, бусад байгууламжуудын орчимд тэмдэг тэмдэглэгээ тавих, олон салаа зам гаргахгүй байх талаар арга хэмжээ авах, ажилчид албан хаагчдад үүрэг өгч байх	Дотоод төлөвлөлтөөр тусгах	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, БОНБУ тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ Энэ стандартаар Монгол орны нутаг дэвсгэр дээрх хөрсөнд агуулагдаж болох бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх (хүлцэх) дээд хэмжээг тогтоох бөгөөд тус стандартад заасан хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг



	Ажилтан албан хаагчдад энэ чиглэлийн анхааруулга санамж өгөх, засварын газар, авто зогсоол, ажилчдын тосгон зэрэг шаардлагатай газруудад самбар гаргах, мэдээллийн хуудас байрлуулах	Тухайн жилдээ 150,000	
Нефтийн бүтээгдэхүүнээр, ахуйн хог хаягдал, бохир усаар хөрс бохирдох	Ажилчдын ахуйн хатуу, энгийн хог хаягдлыг цуглуулах цэгийг зориулалтын болгож янзлах, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах, хөрс бохирдуулагч алдагдсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд тусгагдсан	
	Шатах тослох материалаар машин техникийг цэнэглэхдээ ШТМ алдагдсан ч хөрсөнд нэвчихээргүй байх аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч байх	Дотоод төлөвлөлтөөр	
	ШТМ хөрсөнд алдагдсан үед хусаж авах, саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах, шаардлагатай багаж материалыг байнга бэлэн байлгах	Дотоод төлөвлөлтөөр	

бохирдолд орсон гэж үзнэ.

-

	<p>Ашиглалтын хугацаанд хөрсөнд хүнд металл, хортой бодисын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү илэрвэл саармагжуулах арга хэмжээ авах, бохирдсон хөрсийг хуулж авах зэрэг арга хэмжээ авах ашиглалтын хугацаанд хөрсөнд хүнд металл, хортой бодисын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү илэрвэл саармагжуулах арга хэмжээ авах, бохирдсон хөрсийг хуулж авах зэрэг арга хэмжээ авах</p>	<p>100,0</p>
<p>Агаарын тоосжилт, бохирдол, хөрсний бохирдлын улмаас ургамлын ургах чадварыг бууруулах, алдагдуулах</p>	<p>Ажилчдын түр сууц, суурин, түүний цогцолбороос гарах хатуу, шингэн хаягдлыг зориулалтын тусгай цэгт, эмх цэгцтэй хадгалах, зохих цэвэрлэгээ, халдваржуулалт хийж байгаль орчинд халгүй аргаар тогтмол хугацаанд зайлуулж байх.</p>	<p>Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тусгагдсан</p>

Тухайн бүрт

6	Амьтан	Төслийн хэрэгжилтийн явцад элдэв шавьж өсч үржих, ингэснээр элдэв нянгийн бохирдлын эх үүсвэр бий болох	Төслийн ойролцоо ан амьтан агнахгүй байх, хамгаалах мэдээлэл, сурталчилгаа хийх, анхааруулсан зурагт хуудас байрлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан	
		Хууль бус ан агнах	Төслийн ойролцоо ан амьтан агнахгүй байх, хамгаалах мэдээлэл, сурталчилгаа хийх, анхааруулсан зурагт хуудас байрлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан	
Жилийн дүн 250,000 төг					

6.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 2023 он /Шатахууны агуулах/

№	Сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хугацаа	Зардал /мян.төг/	Хариуцагч	Баримтлах стандарт, аргачлал
1	Шатах тослох материал алдагдсан үед гүний ус бохирдуулах, элдэв нян бактери үржин ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Шатах тослох материал алдагдсан үед саармагжуулах арга хэмжээ авах	Төслийн бүхий л үйл ажиллагааны хүрээнд	Ашиглалтын хугацаанд	100,0	Нисэх буудал	Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт
2	Байгальд удаан хугацаанд задардаггүй нийлэг материалтай	Үүсч буй бүх төрлийн хог хаягдлын төрлийг тодорхойлох ба тэдгээрийг ангилах		Дотоод төлөвлөлтөөр			
	/хуванцар, шил, гялгар уут зэрэг / хог хаягдлыг ил задгай хаясанаар байгаль орчны өнгө үзэмж доройтох, бохирдох	Талбайн гадна болон дотор хог хаягдлыг ангилан ялгаж хийх савнуудыг байрлуулах					
4	Хог хаягдал ихээр хуримтлагдсанаар тэдгээрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг ихсэх	Хог хаягдлыг багасгах үр дүнтэй аргуудыг хэрэгжүүлэх аргыг ашиглалтын явцад судлах					
Хог хаягдлын менежмент төлөвлөгөөнд шаардагдах зардал нийт 100,000төгрөг							

7.Орчны хяналт-шинжилгээний /хөтөлбөр/ төлөвлөгөө 2023 он /Шатахууны агуулах/

Байгаль орчны бүрэлдхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр	Хяналт шинжилгээ хийх, Сорьц авах цэгийн байршил	Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж	Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал	Хяналт шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж	Зарцуулаг-дах төсөв /төгрөг/	Үр дүнг нэгтгэх, тайлагнах арга хэлбэр
Агаар орчин	Тоосжилт	Агаарын найрлага, чанар	Төслийн талбайн ойр орчмоос	цэгээс нөлөөллийн бүс болон нөлөөллөөс гаднах талбайд\	Лабораторийн шинжилгээний арга	Агаараас дээж авагч	2 удаа x 38,500 сар = 77,0	Лабораторын шинжилгээний үр дүнд үндэслэн
Хөрсөн бүрхэвч	Хүнд металл, агрохимийн үзүүлэлт, химийн шинж чанар	Хөрсний химийн найрлага, элэгдэл эвдрэлийн үзүүлэлтүүд	Ачиж буулгах талбай, хогийн цэг, агуулахын хашаан дотор, нүүрсний агуулах	Жилд нэг удаа	Лабораторийн шинжилгээний арга	Хүрз, метр, дээжний уут	Нийт 4 цэгээс 8 дээж авна. 8 дээж x1 44 000 = 352,0	Лабораторын шинжилгээний үр дүнд үндэслэн
	Усан дахь	Унд ахуйн	Ажилчдын	Улиралд	Лабораторийн	Дээжний сав	Ажилчдын гал	Лабораторийн

Ундны ус	нян бактер ийн судалга а	хэрэглээний ус	гал тогоо	нэг удаа	шинжилгээний арга	Жилд 2 удаа	тогоонд хэрэглэж буй усанд химийн болон бактерлогийн бүрэн шинжилгээ хийлгэхэд 46,0x2=92,0	шинжилгээний үр дүнд үндэслэн
Орчны хяналт шинжилгээний зардал 521,000 <b>төгрөг</b>								

8. Удирдлага, зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө 2023 он

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хугацаа	Зардал, сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
1	Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх осол эрсдлийг илрүүлэх, хөдөлмөр хамгаалал болон болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх, осол аваарын үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган цаг үеийн байдалтай уялдуулан тодотгол хийж	Үйл ажиллагааны хүрээнд	2022 онд	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БО багц хуулиуд, холбогдох дүрэм журам стандарт, Усны тухай хууль, ЗГ-н тогтоол, усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай, бусад холбогдох хууль тогтоол, журам,
2	Байгаль орчны аудитын тайланг тухай бүрт нь хийлгэж байх	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	2 жил тутамд	Дотоод төлөвлөлтөөр	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17), MNS5078-2001, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, Үйлдвэрлэлийн эрүүл ахуй”
3	Байгаль орчныг хамгаалах, осол аваарь, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	Жилд 2 удаа	100,0 x2 =200.0	MNS ISO 13688 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын тусгай хувцас-Ерөнхий шаардлага
4	Байгаль хамгаалахад сумын холбогдох ажилтнуудын оролцоог идэвхижүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах,	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	Жилд 1 удаа	100,0	
5	Ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлууд	Нисэх буудлын төлөвлөгөөний дагуу	Жилд 1 удаа	250,0	
Жилийн дүн 550 000төгрөг					

**Баянхонгор нисэх буудлын Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний 2023 оны нэгдсэн дүн**

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	зардал /мян.т/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,740,000
2.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалт	3,000,000
3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	900,000
4.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1700,000
<b>Нийт</b>		<b>7,340,000</b>

**2. Шатахуун агуулах түүний Байгаль орчны менежментийн  
төлөвлөгөөний 2023 оны нэгдсэн дүн**

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	зардал /мян.т/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	250,000
2.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалт	-
3.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	100,000
4.	Орчны хяналт шинжилгээний /хөтөлбөр/ төлөвлөгөө	521,000
5.	Удирдлага зохион байгуулалт менежментийн төлөвлөгөө	550.000
<b>Нийт</b>		<b>1,421,000</b>

“Баянхонгор” нисэх буудлын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2023 оны нийт зардал 8,721,000 төгрөг төлөвлөв.





*Тайлан боловсруулсан: "СОЛОНГОН ТӨГӨЛ" ХХК*

*Тайлан боловсруулсан: "СОЛОНГОН ТӨГӨЛ" ХХК*